



АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
1.1 Зорилго	4
1.2 Хамрах хүрээ	4
1.3 Нэр томъёоны тайлбар.....	4
2. БОДЛОГО	5
2.1 Комплаенсын бодлого.....	5
2.2 Комплаенсын зорилго, зорилт	5
2.3 Зарчим	6
2.4 Уриа үг	6
3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	6
3.1 Комплаенсын бодлогын хариуцлагын матриц	6



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЕНСЫН
БОДЛОГО

Дугаар:
Б22-ТХХ-01-01

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Комплаенсын шаардлага болон үүрэг, амлалтыг чанд мөрдөн, байгууллагын үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээг хариуцлагатай зан үйл болгон төлөвшүүлж, комплаенсын эрсдэлийг удирдан, ёс зүйтэйгээр үйл ажиллагаа явуулахад энэхүү бодлогын зорилго оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд Говь ХК-ийн нийт ажилтнууд, Охин компанийн ажилтнууд, гэрээт компани, ханган нийлүүлэгч болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй ажилтнууд комплаенсын шаардлага болон үүрэг амлалтад үйл ажиллагааг нийцүүлэн, бизнесийн болон ажилтны ёс зүйг эрхэмлэн ажиллахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн дээд шатны удирдлагын амлалт бичиг байна.

1.3 Нэр томъёоны тайлбар

1.3.1 **Комплаенс:** Байгууллага зайлшгүй дагаж мөрдөх шаардлагууд болон дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн үүрэг амлалтыг үйл ажиллагаанд нийцүүлэх чадамж.


Тайлбар: Комплаенсыг тухайн байгууллагын соёл тэнд ажиллаж буй хүмүүсийн зан төлөв болон хандлагад нэвтрүүлэн хэрэгжүүлснээр үр дүнтэй хэрэгжинэ.

1.3.2 **Комплаенсын нэгж:** Комплаенс удирдлагын чиг үүргийг хариуцах ажилтан.

1.3.3 **Комплаенс эрсдэл:** Комплаенс зорилгыг тодорхой бус болгож байгаа нөлөөг хэлнэ.

1.3.4 **Комплаенс шаардлага:** Байгууллага зайлшгүй дагаж мөрдөх ёстой зүйлийг хэлнэ. Жишээ нь: хууль эрх зүйн заалт, засгийн газрын тогтоол, тусгай зөвшөөрөл, лиценз, шүүхийн шийдвэр, шаардлагатай стандарт гэх мэт.

1.3.5 **Комплаенс үүрэг амлалт:** Байгууллага дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн зүйлийг хэлнэ. Жишээ нь: гэрээний зүйл, заалт, байгууллагын дүрэм, журам, заавар, зааварчилгаа гэх мэт.

	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЕНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-01
---	------------------------------------	--------------------------

- 1.3.6 **Комплаенс соёл:** Байгууллагын комплаенсын зан үйл нь хяналтын тогтолцоо, бүтэц зохион байгуулалттай харилцан үйлчилснээр бий болдог үнэт зүйлс, ёс зүй, итгэл үнэмшлийг хэлнэ.
- 1.3.7 **Удирдлагын тогтолцоо:** Байгууллагын харилцан уялдаа холбоо эсвэл харилцан нөлөөллийг бүрдүүлэх зорилгодоо хүрэхэд чиглэсэн үйл явцын цогцыг хэлнэ.
- 1.3.8 **Бодлого:** Байгууллагын баримтлах ерөнхий чиглэл зорилгыг тодорхойлж ажилтнуудад шийдвэр гаргах зөв чигийг зааж өгдөг баримт бичиг.


2. БОДЛОГО

2.1 Комплаенсын бодлого

- 2.1.1 Бизнесийн ёс зүйн зарчимд тулгуурлан комплаенсын шаардлага болон үүрэг амлалтыг үйл ажиллагаандаа нийцүүлэн хөгжүүлж, мэдлэг чадамжийг тасралтгүй нэмэгдүүлэх замаар байгууллагын соёлыг бэхжүүлнэ.

2.2 Комплаенсын зорилго, зорилт

- 2.2.1 Комплаенсын холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгон тэдгээрийг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрх үүрэгт нь тусган өгөх, байнгын идэвхжүүлэлт хийх замаар байгууллагын соёлыг бүрдүүлж, комплаенсын шаардлага болон үүрэг амлалтыг мөрдөн комплаенсын эрсдэлийг бууруулж “ЗӨРЧИЛ=0” байх зорилгын төлөө ажиллана. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:
- 2.1.1.1 Ёс зүйн хэм хэмжээ: Говь ХК-ийн Ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн зарчмыг тулгуур зарчим болгон баримталж, бизнесийн үйл ажиллагааг шударга, хуулийн хүрээнд явуулан, ёс зүйн зөрчлийг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллана.
- 2.1.1.2 Комплаенсын шаардлага болон үүрэг амлалт: Комплаенсын шаардлага болон үүрэг амлалтыг үйл ажиллагаандаа нийцүүлэн, ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулж хуулийн хариуцлага хүлээх болон санхүүгийн алдагдалгүй ажиллахыг зорино.
- 2.1.1.3 Комплаенсын эрсдэлийн менежмент: Учирч болзошгүй комплаенсын эрсдэлийг урьдчилан тодорхойлох, үнэлгээ хийх, дүгнэх, удирдах, мониторингийг тасралтгүй хийж, комплаенсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 80-аас дээш хувиар хэрэгжүүлнэ.

 GOBI MONGOLIAN CASHMERE	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЕНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-01
---	------------------------------------	--------------------------

2.1.1.4 Авлига, ашиг сонирхолоос ангид хуулийн хүрээнд ажиллах: Нийт ажилтнууд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг зорих бөгөөд авлига ашиг сонирхлын судалгааны үр дүнг 5-10 хувиар сайжруулан ажиллана.

2.3 Зарчим

- 2.3.1 Бид бүхий л үйл ажиллагаандаа шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.
- 2.3.2 Ажилтнуудын санал санаачилга, оролцоог нэмэгдүүлэн үл буруутгах зарчмыг баримтлан, тогтолцоог сайжруулан ажиллана.
- 2.3.3 Бид аливаа харилцаанд эрх тэгш, найрсаг, хүндэтгэлтэй байх зарчмыг баримтлана.
- 2.3.4 Компанийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх зарчмыг баримтлана.

2.4 Уриа үг

“ИЛҮҮ САЙХАН ИРЭЭДҮЙН
 ТӨЛӨӨ ЁС ЗҮЙ БОЛОН ДҮРЭМ
 ЖУРМЫГ ДАГАЖ МӨРДЬЕ”


“FOLLOW ETHICS AND RULES
 FOR A BETTER FUTURE”

3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Комплаенсын бодлогын үүрэг, хариуцлага

Хүснэгт 1 Комплаенсын бодлогын хариуцлагын матриц

Процесс	Дээд удирдлага	Дунд шатны удирдлага	Ажилтан	Комплаенсын нэгж
<i>/Г-гүйцэтгэх, Д-дэмжих, Х-хянах, М-мэдээлэл авах, Б-батлах/</i>				
Комплаенсын бодлогыг боловсруулах, батлах	Х, Б	М	-	Г
Комплаенсын бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	-	Д	М	Г
Оролцогч талуудад тохиромжтой байдлаар хүртээмжтэй байдлыг хангах	Д	-	-	Г
Комплаенсын бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Д	Г	Г	Д

 MONGOLIAN CASHMERE	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЕНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-01
---	------------------------------------	--------------------------

Комплаенсын бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	Д	-	-	Г
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	Д	Г	-	Г

- 3.1.1 Байгууллага нь Комплаенсын удирдлагын тогтолцооны бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянах, байнгын сайжруулах замаар комплаенсын шаардлага болон үүрэг амлалтын нийцлийг хангаж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөн комплаенсын эрсдэлийг бууруулна.
- 3.1.2 Менежмент багийн гишүүд нь Комплаенсын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, комплаенсын шаардлага болон үүрэг амлалтын нийцүүлэх ажлыг удирдан, ёс зүйн хэм хэмжээг үлгэрлэн хамт олноо манлайлан ажиллана.
- 3.1.3 Дунд шатны удирдлага нь Комплаенсын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, комплаенсын шаардлага болон үүрэг амлалтын нийцүүлж, ёс зүйн зөв үлгэр дуурайлал үзүүлэн ажиллана.
- 3.1.4 Ажилтан нь Говь ХК-ын Ёс зүйн дүрэм, Комплаенсын бодлого болон бусад дүрэм, журам, заавар, зааварчилгааг чанд мөрдөн, ёс зүйн хэм хэмжээг баримтлан, зөрчлийг мэдсэн бол заавал мэдээлж ажиллана.
- 3.1.5 Охин компани, гэрээт компани, ханган нийлүүлэгчид, гэрээт ажилтнууд нь Говь ХК-ийн Комплаенсын бодлого, дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллана.

ТӨГСӨВ.